



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/118

Мөрөн сум

Барилга байгууламж ашиглалтад оруулах
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 8-р багт баригдсан “Хөх сувд гарден”-ны 12 давхар 84 айлын орон сууцны барилгыг ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Б.Энхжаргал	(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)
Гишүүд:	
Ж.Жавзанпагма	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)
Х.Даваасүрэн	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)
Д.Аюушжав	(Аймгийн Засаг даргын тамгын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
Д.Мягмарсүрэн	(Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга техник хяналтын улсын байцаагч)
П.Даваа-Очир	(Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Өргөх байгууламжийн хяналтын улсын байцаагч)
Э.Дэлгэрмөрөн	(Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Геодезийн мэргэжилтэн)
Ж.Нацагдорж	(Аймгийн онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)
Д.Оюун-Эрдэнэ	(Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн)
Д.Өлзийням	(“Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн хяналт хэмжилтийн инженер)
Д.Сүхээ	(“Хөвсгөл ус суваг” ХХК-ийн Ерөнхий инженер)

6710010482

Г.Даваадорж	(“Хөвсгөл эрчим хүч” ХХК-ийн Ерөнхий инженер)
Ж.Лувсанням	(“Мэдээлэл холбоо сүлжээ” ТӨХК-ийн Ерөнхий инженер)
Ш.Баасанпүрэв	(Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын дэд бүтэц, нийтийн тээвэр хариуцсан мэргэжилтэн, Архитектор)
З.Соёлмаа	(Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

Э.Эрдэнэбилэг	(“Мод Арч” ХХК-ийн Захирал)
---------------	-----------------------------

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

Г.Төгсбаяр	(“Монголиан ойл консалтинг” ХХК-ийн Захирал)
Э.Мөнхбаяр	(“Уудам хишигтэн” ХХК-ийн Захирал)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Г.Бүрнээбаяр	(“Стресс сэвэрс” ХХК-ийн Захирал)
У.Хүчитбаатар	(“Стресс сэвэрс” ХХК-ийн инженер)

Комиссын нарийн бичгийн дарга:

Н.Шинэбаяр	(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Мэргэжилтэн)
------------	--

2. Барилга байгууламжийг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн дотор зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр олон нийтэд сурталчилж ажиллахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Барилга байгууламжийг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Н.Шинэбаяр)-д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга байгууламжийн ажил хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН